

Үндэсний эв нэгдлийн судалгаа, үр дүн

Бүрэнбаярын Содбилэг*

Доктор (Ph.D), төвийн дарга, sodbileg@iss.gov.mn
Монгол Улс, Улаанбаатар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн
Стратеги судалгааны хүрээлэн

Наранболдын Төмөрчодор

Докторант, temurchidur@gmail.com
Монгол Улс, Улаанбаатар, Үндэсний батлан хамгаалахын их сургууль

Хураангуй

Үндэсний эв нэгдэл нь Монгол Улсын нийгмийн тогтвортой байдал, хөгжлийн үндэс бөгөөд иргэдийн үнэт зүйлийн баримжаалал, нийгмийн сэтгэл зүйн төлөв байдал, төрийн бодлоготой салиггүй холбоотой. Сүүлийн жилүүдэд нийгэмд үзэл бодлын ялгаа, хагарал, үл итгэлцэл ажиглагдаж байгаа нь үндэсний эв нэгдлийг бэхжүүлэх чиглэлээр шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаа явуулж, үр дүн дээр суурилсан бодлого боловсруулах шаардлагыг бий болгож байна.

Энэ өгүүллийг 2025 онд гүйцэтгэсэн “Үндэсний эв нэгдлийн тандалт судалгаа”-ны үр дүн дүгнэлт “Биднийг юу хагалан бутаргаж, байна вэ?”, “Биднийг юу нэгтгэж байна вэ?”, “Цаашид үндэсний эв нэгдлийг хэрхэн бэхжүүлэх вэ?” гэсэн үндсэн агуулгын хүрээнд авч үзнэ.

Түлхүүр үг: Үнэт зүйл, эв нэгдэл, нийгмийн ялгарал, үндэсний ондоошил, ижилсэл

Оршил

Үндэсний эв нэгдэл нь улс орны тогтвортой хөгжил, нийгмийн тогтвортой байдлыг хангах үндсэн хүчин зүйл бөгөөд иргэдийн үнэт зүйлсийн баримжаалал, нийгмийн сэтгэл зүйн төлөв байдал, төрийн бодлогын уялдаанаас шууд хамаардаг. Монгол Улс нь олон зуун жилийн түүхэндээ өөрийн өвөрмөц соёл, үнэт зүйл, үндэсний эв нэгдлээ сахин хамгаалж, улс орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хадгалсаар ирсэн. Бид эвлэлдэн нэгдэж хүчирхэг улсыг байгуулж явсан бол хагаран бутарч оршихуйн эгзэгтэй цаг үетэй тулгарч байсан удаа бий. Туулж өнгөрүүлсэн энэ туршлагаас суралцаж улс, үндэстнээрээ нэгдэн нягтарч нэг зорилгын дор хөгжин дэвших сэдэл монгол хүн бүрт байдаг. Гэсэн хэдий ч нийгмийн өөрчлөлт, даяаршлын нөлөө, нийгэм, эдийн засгийн тэгш бус байдлаас улбаатай эмх цэгцгүй, хэт туйлширсан, нэгдмэл зорилгогүй нийгмийн сэтгэл зүйн хэв шинж сүүлийн жилүүдэд ажиглагдах болсон. Үүний үр дагавар нь монгол хүний язгуур мөн чанар, оюун санааны үнэт зүйлийг

* Холбоо барих зохиогч

бүдгэрүүлж, төр, иргэд хоорондын үл ойлголцол, ёс суртахууны доройтол, нийгмийн бүлгүүд хоорондын зөрчил, үл итгэлцлээр илэрч байна. Энэ цаг үед монголчуудын сэтгэлгээний өвөрмөц төлөв байдал, чиг хандлагыг шинжлэх ухааны үндэслэлтэй судалж, нийгмийн зөвшилцөл, үндэсний эв нэгдлийг бэхжүүлэх, соён гэгээрүүлэх арга замыг тодорхойлох нийгмийн хэрэгцээ шаардлага үүсэж байна.

Биднийг юу нэгтгэж байна вэ?

Монголчуудын сэтгэлгээний онцлог, үнэлэмж нь нэг талаас түүх, соёл, уламжлалын нөлөөгөөр бүрэлдэн тогтсон харьцангуй тогтвортой шинжийг агуулж байгаа бол нөгөө талаас орчин үеийн нийгмийн харилцаанд гарч буй өөрчлөлт, мэдээллийн технологийн хөгжилтэй холбоотой шинэ үнэт зүйлсийн элементүүд хүүхэд, залуучуудын сэтгэлгээний чиг хандлагыг тодорхойлж байна.


Судалгааны үр дүнд шинжилгээ хийхэд уламжлал, шинэчлэл хосолсон үнэлэмжийн өвөрмөц хэлбэр нийгмийн сэтгэл зүйд төлөвшиж буй байдал ажиглагдлаа. Тухайлбал: судалгаанд оролцогчдын дийлэнх буюу 28.7 хувь нь “гэр бүл, эцэг эх” хэмээх үнэт зүйлсийг сонгосон нь монголчуудын амьдралд гэр бүл, эцэг эх онцгой байр суурь эзэлдэг уламжлалт сэтгэлгээ одоог хүртэл хадгалагдан үлдэж, амьдралын хэв маягт чухал нөлөө үзүүлж байна гэж үзэж болохоор байна.

Харин судалгаанд оролцогчдын 25.5 хувь нь “эх орон, газар нутаг” хэмээх үнэт зүйлийг нэгдүгээрт эрэмбэлсэн нь монголчуудын хувьд эх орон, газар нутаг нь зөвхөн газар зүйн хэмжээний ойлголт биш, түүх, өв соёл, уламжлалтай холбоотой тухайн орон зайг хайрлан хамгаалах, түүнийг авч үлдэх гэсэн сэтгэлгээний өвөрмөц хэлбэрээр илэрч байгаа юм. Хүний нийтлэг үнэт зүйл болох “эрүүл мэнд” 17.2 хувийг эзэлж байна. Монголчуудын энэ үнэлэмжийг үндэсний эв нэгдлийг бэхжүүлэх агуулгаар харвал эрүүл мэнд нь хүний амьдралын чанар, бүтээмж, нийгмийн тогтвортой байдалд чухал нөлөө үзүүлдэг. Иймд нийгмийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах нь нийгмийн эв нэгдлийг бэхжүүлэх, иргэд хоорондын харилцан итгэлцлийг нэмэгдүүлэхэд чухал дэмжлэг болох хүчин зүйл юм.

Хэдийгээр “шударга ёс” 3.2 хувь болон “эрх чөлөө” 4.2 хувийг эзэлж, монголчуудын амьдралд чухал нөлөө үзүүлж байгаа боловч бусад үнэт зүйлстэй харьцуулахад харьцангуй бага хувийг эзэлж байна (График 1) (ҮАБЗ-ийн Стратеги судалгааны хүрээлэн, 2025, р. 20). Иймд нийгмийн институтын уялдаа холбоог сайжруулах, харилцан итгэлцлийг нэмэгдүүлэхэд орчин үеийн үнэт зүйлсийн чиг хандлагыг тусгах, үндэсний эв нэгдлийг бэхжүүлэхэд харгалзан үзэх нь чухал юм.

График 1. Та амьдралдаа дараах үнэт зүйлсийн алийг илүү чухалчилдаг вэ?

Дээрх судалгааны дүнгээс нэгтгэн дүгнэвэл монголчуудын үнэт зүйлсийн



баримжааллын онцлог тал нь түүх, соёл, уламжлалаас өвлөгдөн ирсэн үнэт зүйлс тэдний сэтгэлгээний төвд оршин байгаагаар илэрч байна. Иймд үндэсний эв нэгдлийг бэхжүүлэхэд “**гэр бүл-эх орон-эрүүл мэнд**” гэсэн монголчуудын суурь үнэлэмж дээр тулгуурлан тодорхой үе шаттай харилцан уялдаатай бодлого хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Үндэсний эв нэгдлийг хангахад үндэсний ухамсар, итгэл үнэмшлийн нэгдмэл байдал чухал нөлөөтэй. Аливаа улс үндэстэн угсаа гарвал, түүх, газар нутаг, үндэсний уламжлалт зан заншлын хувьд бусад улс орноос ялгарч үндэсний ижилслийг бүрдүүлдэг. Энэхүү ижилсэл нь тухайн улсын үндэсний соёл, зан заншил, уламжлалт ахуйн онцлогт тулгуурлан хөгжиж үндэсний ой санамж буюу оюун санааны дархлааг суулгаж байдаг.

Монголчуудын уламжлалт соёлыг тээж буй Цагаан сар, Үндэсний их баяр наадмыг түүхэн ёс жаяг, уламжлалын дагуу нутаг ус, жалга довны үзлээс ангид тэмдэглэн өнгөрүүлж, үндэсний эв нэгдлийн хөшүүрэг болгон ашиглах нь чухал юм.


Судалгаанд оролцогчдын олонх буюу 32.2 хувь нь Үндэсний их баяр наадмыг гадаад, дотоодод үндэсний соёл, өв уламжлалаа сурталчлан таниулах чухал ач холбогдолтой баяр гэж үзжээ. Энэ нь соёлын өвийг түгээн дэлгэрүүлэх, уламжлалт үнэт зүйлсийг залуу үеийнхэнд өвлүүлэх асуудлыг чухалчилж байгаагийн нэг илрэл. Мөн Үндэсний их баяр наадмыг зөвхөн уламжлалт арга хэмжээ төдий бус үндэсний эв нэгдлийн баяр болгон тэмдэглэх нь зүйтэй гэж 17.1 хувь нь хариулсан бол төр, ард түмний итгэлцлийг бэхжүүлэх баяр болгон тэмдэглэх нь зүйтэй гэж 13.5 хувь нь хариулжээ. Эдгээр гурван хариултыг нийт судалгаанд оролцогчдын 62.8 хувь нь сонгосон байна (График 2) (ҮАБЗ-ийн Стратеги судалгааны хүрээлэн., 2025, р. 21).

График 2. Таны бодлоор Үндэсний эв нэгдлийг бэхжүүлэхийн тулд Үндэсний их баяр наадмыг хэрхэн тэмдэглэх нь зүйтэй вэ?



Цагаан сарын баярын тухайд судалгааны оролцогчдын дийлэнх буюу 67 хувь нь ураг төрөл, гэр бүлийн хүрээнд, ахмад настануудаа хүндэтгэн эгэл даруу тэмдэглэх ёстой гэсэн бол 28.5 хувь нь өргөн дэлгэр, элбэг тансаг тэмдэглэх нь зүйтэй гэж үзэж байна (График 3) (ҮАБЗ-ийн Стратеги судалгааны хүрээлэн., 2025, р. 22). Өөрөөр хэлбэл: Ураг төрлөө мэдэлцэх, ахмад настнаа хүндэтгэх, гэр бүлийн үнэ цэнийг өргөх энэхүү уламжлалт баяр ёслолыг хэт их зардал, баян хоосны ялгаа гаргаж гажуудуулахгүй **нэг үндэстэн** хэмээх үнэт зүйл, итгэл үнэмшлийн баяр болгон тэмдэглэх эрмэлзэл олон нийтэд байна.


График 3. Таны бодлоор Үндэсний эв нэгдлийг бэхжүүлэхийн тулд Цагаан сарын баярыг хэрхэн тэмдэглэх нь зүйтэй вэ?



Нийгмийн сэтгэл зүй бухимдалтай, зөрчил, тэмцэл, ёс суртахууны сөрөг хандлага давамгайлах шинжтэй боловч монгол хүний уламжлалт суурь хүмүүжил, язгуурын мөн чанар бүрэн алга болоогүй гэж дүгнэж болохоор байна. Үр хүүхдэдээ эх орноо хайрлах, өвөг дээдсээ хүндлэх, ёс жудагтай, хүний мөс чанартай байх,

үндэсний өв соёл, зан заншлаа хадгалах зэрэг уламжлалт суурь хүмүүжил олгодог гэр бүл олон байна. Гагцхүү даяаршил, мэдээллийн үлэмж их урсгал, гадны соёл иргэншлийн түрлэгийн нөлөөгөөр саармагжих, бүдгэрэх хэв шинж ажиглагдаж байгаа юм. Судалгаанд оролцогчдын зүгээс монгол хүн дасан зохицох чадвартай, хүнлэг, энэрэнгүй сэтгэлтэй, найрсаг, зочломтгой зан, эх орноо гэсэн сэтгэлтэй, уламжлал соёлоо дээдлэх, уужуу тайван ухаан, эрэмгий дайчин байдал зэрэг олон сайхан шинж бүрдмэл бий гэж үзжээ (График 4) (ҮАБЗ-ийн Стратеги судалгааны хүрээлэн., 2025, р. 22).

График 4. Таны бодлоор Монгол хүний сайн сайхан чанар юу вэ?




Үндэсний эв нэгдлийг бэхжүүлэх, нийгмийн оюун санааг соён гэгээрүүлэхийн тулд монгол хүний сайн сайхан шинж чанарыг түгээн дэлгэрүүлэх, эх оронч үзэл, үндэсний ой санамжийг сэргээх асуудал чухал болох нь энэ удаагийн судалгаанаас харагдаж байна. Эдүгээ даяаршлын эрин үед гадны нийгэм, улс төр, эдийн засаг, соёл иргэншлийн нөлөөнд уусаж бүдгэрэхээс сэргийлэх, цаашилбал тэсэж үлдэхийн тулд эх оронч үзэл санаанд тулгуурласан “Үндэсний эв нэгдлийг бэхжүүлэх стратеги” боловсруулж, үүнийг тунхаг төдий бус бодитоор хэрэгжүүлэх нь чухал юм. Энэ нь зөвхөн соёлын салбарын хийх ажил биш бөгөөд нийгмийн бүхий л салбарын оролцоотойгоор боловсролын тогтолцоогоор дамжуулан үндэсний ой санамж, оюун санааны дархлааг суулгах зэрэг байж болох юм. Зөвхөн хүүхэд гэхгүй нийт хүн амын нас, хүйс, боловсрол зэрэгт тохирсон хувилбарууд байж болох талтай. Үүнийг нийгмийн хөрс хүлээн авах боломжтой.

Судалгаанд оролцсон иргэдээс хамгийн олон буюу 20 орчим хувь нь монголчуудыг **эх оронч үзэл** нэгтгэнэ гэсэн хариултыг сонгожээ. Өөрөөр хэлбэл: Эх оронч үзэл тулгуур болох боломжтой байна. Эх оронч үзлийг тулгуур болгохоос гадна эрүүл, шударга нийгэм, үндэсний хэл, соёл, түүх, онгон дагшин байгаль зэргээр баяжуулан эх орныхоо сайн сайхныг сурталчилсан дүрс бичлэг-контент, зэрэг уур амьсгал, нийгмийг соён гэгээрүүлэхэд чиглэсэн нэвтрүүлэг, ярилцлага

зэргийг олон нийтэд хүргэх нь үндэсний эв нэгдлийг бэхжүүлэх тулгуур болох нь тоон судалгааны дүнгээс харагдаж байна (График 5) (ҮАБЗ-ийн Стратеги судалгааны хүрээлэн., 2025, р. 23).

График 5. Таны бодлоор монголчуудыг юу нэгтгэх вэ?



Монголчуудын нэгдмэл үзэл санааны тухайд тоон болон чанарын судалгааны дүн ойролцоо гарч байна. Нээлттэй асуултад нийт 430 орчим иргэн хариулт өгсөн. Үүнээс 27.0 хувь буюу 116 иргэн **“Монголын түүх, хэл, соёл, ёс заншил монголчуудыг нэгтгэж, нэгдмэл болгож чаддаг”** гэж үзсэн бол 20.2 хувь буюу 87 иргэн **“Монгол Улсын газар нутаг, тусгаар тогтнол монголчуудыг нэгтгэж, нэгдмэл болгож байна”** гэж тус тус хариулжээ. Монголчуудын эв нэгдлийн тулгуур нь түүхэн уламжлал, хэл, соёл, зан заншил гэх сэтгэлгээний ба үнэт зүйлсийн нэгэн жигд орон зайд оршиж байхад, нөгөө талаас улс орны тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдал нь аюулгүй байдлын ухамсарт гүн суусан хүчин зүйл болж, иргэдийн хувьд нэгдмэл байдлын зайлшгүй баталгаа хэмээн ойлгогдож байгаа нь ажиглагдаж байна.

Ийнхүү иргэдийн дунд нэгдмэл байдлын талаарх ойлголт нь соёлын нэгдэл болон тусгаар тогтнолын үнэ цэнийг хослуулсан, харилцан уялдаатай үзэл санаа хэлбэрээр төлөвшиж буй нь тоон болон чанарын судалгааны дүнгээр нотлогдож байгаа бөгөөд үндэсний эв нэгдлийн суурь ойлголт нийтлэг шинжтэй, тогтвортой төлөв байдалтай байгааг харуулж байна.

Түүнчлэн иргэдийн эх оронч үзэл санаа, Цагаан сар болон Үндэсний их баяр наадам нь монголчуудын эв нэгдлийг бэхжүүлэхэд чухал хүчин зүйл гэж үзэж байна (Хүснэгт 3). Иймд үндэсний эв нэгдлийг бэхжүүлэх бодлогын хүрээнд боловсролын салбарт Монголын түүх, хэл, соёлын агуулгыг баяжуулж, технологийн дэвшилтийг ашиглан шинэлэг хэлбэрээр түгээх, соёлын өвийг хамгаалж, уламжлалт ёс заншил, зан үйлийг сэргээн нутагшуулах шаардлагатай байна. Мөн иргэдэд газар нутаг,


тусгаар тогтнолын ач холбогдлыг ойлгуулах боловсрол, мэдээллийн хөтөлбөр хэрэгжүүлэх, Цагаан сар, Үндэсний их баяр наадам зэрэг уламжлалт баярыг бүх нийтийг хамарсан эв нэгдлийн бэлгэ тэмдэг болгон хөгжүүлэх, хүүхэд залуучуудад илүү хүртээмжтэй хэлбэрээр хүргэх нь ач холбогдолтой.

Биднийг юу хагалан бутаргаж, байна вэ?

Нийгмийн оюун санааны сэтгэлгээнд эерэг, сөрөг хандлага хэр түвшинд байгааг тандах зорилгоор судалгаанд оролцогчдыг эсрэгцсэн утга бүхий нөхцөл байдлаас аль нэгийг нь сонгуулахад 35.1 хувь нь нийгэмд ёс суртахууны сөрөг хандлага давамгайлж байна гэж үзсэн бол 32.7 хувь нь эерэг хандлага давамгайлж байна гэж үзжээ. Үлдсэн 32.2 хувь нь мэдэхгүй гэсэн хариултыг сонгосон байна. Түүнчлэн 34.1 хувь нь аз, сүсэг бишрэлд найдсан ухамсарт бус сэтгэлгээ, 32.1 хувь нь тооцоолол, баримтад суурилсан ухамсарт сэтгэлгээ давамгайлж байна гэж үзжээ.


Харин нийгмийн сэтгэл зүйн тогтворгүй байдал, иргэдийн гадаадад амьдрах хүсэл эрмэлзэл гэсэн үзүүлэлт эсрэг үзүүлэлтээсээ 1.5 дахин илүү байна. Өөрөөр хэлбэл: Нийгмийн сэтгэл зүйн тогтворгүй байдал, тулгамдсан асуудлаас үүдэн иргэд эх орондоо амьдрахаас илүүтэй гадаад улсад ажиллаж, амьдрах хүсэл эрмэлзэлтэй байна (График 6) (ҮАБЗ-ийн Стратеги судалгааны хүрээлэн., 2025, р. 8).

График 6. “Таны ажиглаж байгаагаар эсрэгцсэн утга бүхий нөхцөл байдлаас аль нь давамгайлах хандлагатай байна вэ?” асуултад хариулсан байдал




Нийгмийн сэтгэл зүй тогтворгүй байдалд ороход гол нөлөөтэй хүчин зүйл болох улс төр, нийгэм, цаг үеийн асуудлаас үүдэлтэй иргэд үзэл бодлоор талцан хуваагдах, нэгдэн нягтрахаас илүүтэй хагаран бутрах, зөвшилцөж ойлголцохоос илүүтэй, зөрчилдөн тэмцэлдэх хэв шинж ажиглагдаж байна (График 7) (ҮАБЗ-ийн Стратеги судалгааны хүрээлэн., 2025, р. 8).

График 7. “Таны ажиглаж байгаагаар нийгэмд аль хандлага давамгайлж байна вэ?” асуултад хариулсан байдал



Нийгэмд зөрчил, тэмцэл үүсгэж буй хүчин зүйлс, түүний учир шалтгааныг тодруулахад улс төрийн нам, бүлэглэл, хөрөнгө орлогын ялгаатай байдал хамгийн их зөрчил үүсгэж байна гэж хариулсан дүн гарчээ. Хот, хөдөөгүй улс төржилт, намчирхах үзэл давамгайлсан ялгарлын гаж бүтэц бий болсноор нийгмийг талцах, хуваагдах байдалд оруулж байна. Түүнчлэн гучин жилээр зааглагдаж буй эрс тэс хоёр нийгмийн төлөөлөл, бие хүний төлөвшлөөс үүдэлтэй насны ялгаа, суурин соёл иргэншил, технологийн хөгжлөөс үүдэлтэй хот хөдөөгийн ялгаа, уламжлалт нутаг усны ялгаа зэрэг үзэгдэл үндэсний эв нэгдлийг сарниулах гол хүчин зүйл болж байна (График 8) (ҮАБЗ-ийн Стратеги судалгааны хүрээлэн., 2025, р. 9).

График 8. Таны ажиглалтаар нийгмийн амьдралд ямар ялгарал илүүтэй зөрчил үүсгэж байна гэж бодож байна вэ?



Цаашид үндэсний эв нэгдлийг хэрхэн бэхжүүлэх вэ?

Үндэсний эв нэгдлийг хангах, нийгмийн зөрчил, үл итгэлцлийг бууруулах, монголчуудын нийтлэг үнэт зүйлийг тодорхойлж, бэхжүүлэхэд дараах санал дэмжлэг болно гэж найдаж байна.

1. Үндэсний үнэт зүйлсийг тодорхойлон бэхжүүлэх

Хамтын хүчээр, нэгдмэл үзэл бодлоор улс үндэстнийхээ нийтлэг үнэт зүйлсийг тодорхойлж, тэдгээрийг ард иргэдийн ухамсарт төлөвшүүлэн бэхжүүлэх бодлого хэрэгжүүлэх нь чухал байна.

- Үндэсний үнэт зүйлийн судалгаа, тодорхойлолт: Монголчуудыг нэгтгэж буй гол үнэт зүйлсийг тодорхойлж, бодлогын бичиг баримтад тусгаж, нэгдсэн нэг ойлголттой болгох;
- Үндэсний түвшинд хэрэгжүүлэх зорилтот ажил: Эв нэгдлийг дэмжих, эх оронч үзэл, үндэсний бахархлыг өдөөхөд чиглэсэн соён гэгээрүүлэх ажлуудыг орон даяар зохион байгуулж, эрчимтэй өрнүүлэх;
- Хэвлэл мэдээлэл, контент хөгжүүлэлт: Үндэсний эв нэгдлийг хангах, хамгаалах, бэхжүүлэх бодлогын хүрээнд Монголын үндэсний олон нийтийн телевиз, радиог чиглүүлж ажиллуулах, эв нэгдлийг хөхиүлэн дэмжих агуулгатай кино, контент, баримтат нэвтрүүлэг, нийтлэл, ярилцлага, олон нийтийн хэлэлцүүлгийг дэмжих бодлого хэрэгжүүлэх;
- Боловсролын хөтөлбөрт тусгах: Бүх шатны боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөрт үндэсний өв соёл, эв эийн сэтгэлгээ, эх оронч үзэл, үнэт зүйлсийн талаарх тусгай агуулгыг насанд нь тохирсон хэлбэрээр, системтэй суулгаж хүүхэд, залуусын ухамсарт төлөвшүүлэх.

2. Нийгмийн зөрчил, ялгарал, үл итгэлцлийг бууруулах

Зөрчил үүсгэж буй нийгмийн бүлгүүдийн ялгарал, үл ойлголцлыг бууруулах, үндэсний нийтлэг эрх ашгийг дэмжих чиглэлээр бодлогын арга хэмжээ хэрэгжүүлэх шаардлагатай.

- Иргэдийн төрд итгэх итгэлийг нэмэгдүүлэх: Төрийн байгууллагууд иргэдтэй шууд харилцах, санаа бодлыг нь сонсох механизм (иргэний зөвлөл, нээлттэй уулзалт, оролцооны цахим платформ) бий болгох, нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд гарч буй хүндрэл, бэрхшээлийг олон нийтэд ойлгуулах, төрд үл итгэх байдлыг бууруулах, нээлттэй засаглалыг дэмжих;
- Нийгмийн бүлгүүд хоорондын ойлголцлыг нэмэгдүүлэх: Хот, хөдөөгийн, залуу үе, ахмад үеийн улс төрийн үзэл баримтлалын ялгааг бууруулах, намчирхах үзлээс ангижруулах, намын эрх ашгаас үндэсний эрх ашиг дээгүүр болохыг ойлгуулах, сурталчлан таниулах;

- Нийгмийн сүлжээн дэх туйлширалыг сааруулах бодлого: Олон нийтийн сүлжээнд хэт туйлширсан үзэл, хуваагдал үүсэхээс сэргийлэх зохицуулалт хийх, эерэг агуулгыг дэмжих;
- Нийгмийн зөрчилдөөн үүсэхээс урьдчилан сэргийлэх: Нийгмийн бүлгүүдийн дунд үүсэж болзошгүй зөрчил, үл ойлголцлыг эрт илрүүлж, урьдчилан шийдвэрлэх зорилготой хяналтын систем, эрдэмтдийн зөвлөл байгуулах.

3. Улс төрийн тогтвортой байдал, эв нэгдлийг хангах

Улс төрийн туйлшрал, хэт өрсөлдөөн, эрх баригчид, сөрөг хүчний үл ойлголцол нь олон нийтийн итгэлцлийг сулруулж, дотоодын зөрчилдөөнд хүргэж буй тул улс төрийн орчныг илүү тогтвортой болгох шаардлагатай.

- Улс төрийн намуудын эв нэгдэл, зөвшилцлийг дэмжих: Улс төрийн намуудын хооронд эрүүл өрсөлдөөн бий болгох, эв нэгдлийг хөхиүлэн дэмжих механизм боловсруулах;
- Бодлогын залгамж чанарыг хангах: Сонгууль бүрийн дараа бодлого өөрчлөгддөг байдлыг багасгаж, урт хугацааны стратегийн зорилтуудад тууштай байх механизмыг бий болгох;
- Шударга, ил тод улс төрийн орчин бүрдүүлэх: Улс төрийн үйл ажиллагаа, шийдвэр гаргах процессыг илүү нээлттэй, хариуцлагатай болгох.
- Олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх: Улс төрийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх.

4. Үндэсний эв нэгдлийг дэмжих урт хугацааны стратеги, үзэл баримтлал боловсруулах

Үндэсний эв нэгдлийг бэхжүүлэх бодлого нь дан ганц нэг удаагийн үйл ажиллагаа биш, харин урт хугацааны стратегийн хүрээнд хэрэгжих ёстой.

- “Үндэсний эв нэгдлийн стратеги” боловсруулах: Төрийн болон иргэний нийгмийн байгууллагууд, эрдэмтэн судлаачид, олон нийтийн оролцоотойгоор урт хугацааны үндэсний эв нэгдлийн стратегийг боловсруулах;
- Судалгааг тогтмолжуулах, өргөтгөх: Үндэсний эв нэгдлийн төлөв байдлыг үнэлэх, жил бүр тандалт судалгаа хийж, үр дүнг бодлогод тусгах, судалгааны ажлыг өргөтгөж, Монгол Улсын 21 аймаг, сум, нийслэлийн иргэдийг хамарсан суурь судалгаа хийх;
- Үндэсний эв нэгдлийн зөвлөл байгуулах: Бие даасан судалгааны болон бодлогын зөвлөл байгуулж, төр, иргэд, судлаачдын хамтын ажиллагааг хангах зэрэг болно.

Дүгнэлт

Монгол Улсад үнэт зүйлсийн тодорхой баримжаа, тогтсон чиг хандлагагүй хүмүүс, нийгмийн нэлээд хэсгийг бүрдүүлж байгаа нь нийгмийн сэтгэлгээний эерэг

өөрчлөлтийг бий болгох, төрийн урт хугацааны бодлогыг хэрэгжүүлэхэд сорилт болох магадлалтай байна.

Нийгмийн бухимдал их байгаа төлөв байдал нь дотоодын зөрчил тэмцэл тодорхой давтамжтай байнга гарах суурь нөхцөл бүрэлдэн бий болсныг харуулж байна.

Монголчуудын үнэт зүйлсийн баримжаалал газар, нутаг төвтэй байгаа нь нэг талаас үндэсний аюулгүй байдлын дархлааг бэхжүүлэх гол хүчин зүйл болж байгаа хэдий ч нөгөө талаар эдийн засгийн мега төсөл хэрэгжүүлэхэд иргэдийн сэтгэлгээний энэ төлөв байдлыг улс төрийн болон эдийн засгийн зорилгоор сөргөөр ашиглах явдал их байна.

Монгол Улсын хувьд үндэстэн хоорондын болон шашин шүтлэгийн ялгаатай байдлаас үүдэлтэй зөрчил, тэмцэл гарах магадлал бага хэдий ч нийгэмд давхаргын гаж бүтэц бүрэлдэх, нийгмийн ялгарал гүнзгийрэх үндсэн шалтгаан болох улс төрийн үзэл бодол, эрх мэдэл, албан тушаал, хөрөнгө орлогын ялгаа ихэссэн нь нийгмийн тогтвортой байдалд эрсдэл учирч болохуйц түвшинд хүрээд байна. Улмаар иргэдэд ирээдүйдээ итгэх итгэлийг нэмэгдүүлэх, төрийн бодлогод иргэний нийгмийн оролцоог хангах, улс үндсээрээ бахархах, уламжлал соёлоо хойч үедээ өвлүүлэх бүхий л салбарыг хамарсан уялдаа холбоотой бодлого шаардлагатай байна.

Үндэсний хэмжээнд улс төржилт нийгмийн амьдралын бүхий л хүрээнд нөлөөлж байгаа нь нийгмийн тогтвортой байдал, төрийн бодлогын залгамж чанар алдагдах нөхцөлийг бүрдүүлж байна.

Нийгмийн ялгарлыг багасгах гол хөшүүрэг, дархлаа болсон монголчуудын уламжлал соёлыг тээж буй Цагаан сар, Үндэсний их баяр наадмыг түүхэн ёс жаяг, уламжлалын дагуу нутаг, усны ялгаа, жалга довны үзлээс ангид тэмдэглэн өнгөрүүлж, эв нэгдлийн бэлгэ тэмдэг болгож үндэсний бахарлыг өдөөн сэргээх чухал ач холбогдолтой арга хэмжээ болгох шаардлагатай байна.

Эх сурвалжийн жагсаалт

ҮАБЗ-ийн Стратеги судалгааны хүрээлэн., У. 2. (2025). *Үндэсний эв нэгдлийн судалгаа*. Улаанбаатар.

Study on National Unity and its Results

Sodbileg Burenbayar*

Doctor (Ph.D), Head of Center, sodbileg@iss.gov.mn
The Institute for Strategic Studies,
National Security Council, Ulaanbaatar, Mongolia

Tumurchudur Naranbold

Ph.D., candidate, temurchidur@gmail.com
Mongolian National Defense University, Ulaanbaatar, Mongolia

Abstract

National unity is a fundamental pillar of social stability and sustainable development in Mongolia, closely intertwined with citizens' values, collective psychology, and government policy. Recent years have witnessed growing social fragmentation, ideological polarization, and mutual distrust, emphasizing the urgent need for evidence-based research to guide policies aimed at strengthening cohesion. This study is based on the 2025 "Survey on National Unity," which investigates the principal factors that both divide and unite Mongolian society. It examines social perceptions, trust in institutions, and cultural and historical influences that shape collective identity and public attitudes. Drawing on these insights, the article proposes actionable strategies and policy recommendations to reinforce national solidarity, promote social consensus, and enhance the capacity of governance frameworks to address emerging societal challenges.

Keywords: *Value, Unity, Solidarity, Social Differentiation, National Distinctiveness, Identity*

* Corresponding author

Received: September 1, 2025 | Accepted: September 8, 2025 | Published online: October 13, 2025



© The Author(s) 2025
<http://creativecommons.org/licenses/by/4.0/>.